



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ИНФОГРАФИК ТАЙЛАН

ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН
ЗОРИУЛАЛТААР ОЛГОСОН ГАЗАР,
АШИГЛАЛТЫН ҮР ДҮН

ГАЗАР ОЛГОЛТ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГОД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗОРИУЛАЛТ БУСААР БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ
ЭРСДЭЛ ҮҮСЭЭД БАЙНА.
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭНД ЗАЙЛШГҮЙ ЭЗЭМШҮҮЛЭХ
ГАЗРЫГ ХУУЛЬД НАРИЙВЧЛАН ЗОХИЦУУЛААГҮЙГЭЭС ЭДИЙН
ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХГҮЙГЭЭР ҮР ДҮНГҮЙ ЭЗЭМШИЖ БАЙНА.



АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар нийт 1,444. сая төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага, 14 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт зөрчлийн дүн

1,444.7

Албан шаардлага

1

Зөвлөмж

14




Аймаг, сумдын газар зохион байгуулалтын болон нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөгүй газар олгосон нь хууль, журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байна.

НУТАГ ДЭВСГЭРИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан сум



15



■ Төлөвлөгөөгүй ■ Төлөвлөгөөтэй

Нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөгүй сум




1



Газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр 2023-2024 онд нийт 153,532.3 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахаар тусгасан бөгөөд хэрэгжилтийн хүрээнд 139,591.0 га газрыг олгожээ.

Нэгж талбарын тоо




ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/





Газар эзэмших, ашиглах гэрээ байгуулан 202.1 мянган га газрын 22499 нэгж талбарт олгосон байна. Үүнээс 135 төрийн байгууллагад 3.4 мянган га газрыг 1026 нэгж талбарт төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэгт хамааралгүй зориулалтаар олгожээ.

Төсөвт байгууллагад олгосон газар



- Боловсролын байгууллага
- Орон нутгийн байгууллага
- Соёлын байгууллага
- Эрүүл мэндийн байгууллага
- Орон нутгийн өмчит компани
- Улсын төсвийн байгууллага



Нийт 22499 нэгж талбарын 5625 нэгж талбарт санамсаргүй түүврийн аргаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд зориулалтын дагуу хоёр жил дараалан ашиглаагүй, хөрөнгө оруулалт хийгээгүй, зөвшөөрөлгүй газарт дур мэдэн барилга байгууламж барьсан 245 нэгж талбар байна.



Газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийг хуульд нийцүүлэн гаргасан боловч зарим аж ахуйн нэгж зөвшөөрөлгүй газар ашиглах, олгосон хэмжээнээс хэтрүүлэн ашиглах зөрчил түгээмэл байна.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ЗОРИУЛАЛТААР ОЛГОСОН ГАЗАР, АШИГЛАЛТЫН ҮР ДҮН



Эзэмшил газрыг зөвшөөрөлгүй сунгасан, захирамж, гэрчилгээний хэмжээ зөрсөн, мэдээллийн санд мэдээлэл дутуу бүртгэгдсэн зэрэг 186 нэгж талбар газар байна.



Газрын бүртгэлийн зөрчлүүд арилахгүй байгаа шалтгаан нь газар эзэмшиж буй иргэд нь өөр аймаг, сум, хот руу шилжсэн, нас барсан, бичиг баримтын зөрчлийг арилгах хүсэлтээ өгдөггүй, зөвшөөрөлгүйгээр захирамжийн дээрх газрын хэмжээнээс илүү эзэмшил газрыг сунган дураараа ашигладаг зэргээс шалтгаалж байна.



Газар эзэмших эрх шилжүүлэхтэй холбоотой шийдвэрийн ихэнх нь хуульд нийцсэн боловч газрын байршил, хэмжээ, зориулалт өөрчлөх талаар эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байдгаас зарим шийдвэр хуулийн холбогдох заалтыг зөрчиж гарсан байна

Эзэмших эрх шилжүүлсэн

3 нэгж талбарын



1410
M2 газар

Зориулалт өөрчилсөн

3 нэгж талбарын



6301
M2 газар

Хэмжээ өөрчилсөн



14 нэгж талбарын
хэмжээг
2692 га
нэмэгдүүлсэн




Газрын төлбөрийг дутуу ногдуулж, хуулийн хугацаанд бүрэн төвлөрүүлээгүй нь орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт хангалтгүй, хуримтлагдсан өр, авлага өсөх нөхцөл бүрдсэн байна.

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ 2023-2024 ОН /САЯ, ТӨГРӨГ/



Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд 75 байгууллага 2024 оны газрын төлбөрийн авлагын 55.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй, жилийн эцсийн тооцоо хийж баталгаажуулдаггүй, төрийн байгууллагууд хоорондоо уялдаа холбоогүй ажиллаж байна.

Газрын төлбөрийн өр



2023 онд 534.8 сая төгрөг
2024 онд 52.2 сая төгрөг



Газрын мэдээллийн системд нэгж талбарын мэдээллийг 98.8 хувьтай оруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.



Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан боловч зарим зөрчлүүд давтагдан гарч байна



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний биелэлтийг зарим сумд сумын ИТХ-аар хэлэлцүүлэн дүгнүүлээгүй байна.



Газрын төлбөрийн ногдуулалт, хяналт сул байсан нь орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд саад учруулж, төлбөрийн өр, авлагыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.



Газрын төлбөрийн ногдуулалт, хяналт сул байсан нь орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд саад учруулж, төлбөрийн өр, авлагын өсөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Мэдээллийн системийн хэрэгжилт сайн боловч өмнөх зөрчил давтагдсан нь хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна.



Газрын төлбөрийг дутуу ногдуулж, хугацаанд бүрэн төлүүлээгүй нь орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг бууруулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-ын дарга Ж.Ганболд танаа

Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тогтмол хяналт тавьж ажиллах

Аймгийн Засаг дарга О.Пүрэв-Очир танаа

Аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хуульд нийцүүлэн батлуулах, батлагдсан төлөвлөгөөний дагуу газрын олголтыг хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх,

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Ү.БЯМБАСҮРЭН танаа:

Зөвшөөрөлгүй газрын хэмжээ өөрчилсөн, дур мэдэн барилга байгууламж барьсан иргэн, хуулийн этгээдэд хяналт, шалгалтыг тогтмол явуулж, зөрчлийг шуурхай арилгах,

Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үүргийн биелэлтийг жил бүр дүгнэж, гэрээний үүргийг биелүүлээгүй газар эзэмшигчийн эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг шат шатны Засаг даргад хүргүүлж, хяналт тавьж ажиллах,

Газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн ногдуулж, газрын төлбөрийн ногдуулалт, хяналтын үйл ажиллагааг сайжруулж, орлогын бүрдүүлэлт, төлбөрийн биелэлтийг тооцож, авлагын хуримтлалыг багасгах нэгдсэн арга хэмжээ авч ажиллах,